

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 дугаар сарын 09

Дугаар 55

Улаанбаатар хот

Хороодын хамтарсан багт
санхүүжилт олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.14 дэх заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.4 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт, Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/380 дугаар тушаалаар батлагдсан Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын наймдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн 43 хорооны Хамтарсан багт дэмжлэг үзүүлэх зорилгоор сар бүр тогтмол санхүүжилтийг олгосугай.

2. Хамтарсан багийн үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр төлөвлөн, үйл ажиллагааны тайланг сар бүр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд ирүүлэхийг Хамтарсан багийн ахлагч (хороодын Засаг дарга) нарт даалгасугай.

3. Тус санхүүжилтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас гаргахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан), Ерөнхий нягтлан бодогч (Г.Төрхүү) нарт зөвшөөрсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилт болон хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Ч.Мэндсайхан)-д үүрэг болгосугай.

5. Тогтоол батлагдсантай холбогдуулан Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны А/07 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.БАЯР